

“АСБИ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 сарын 30-ны өдөр	Дугаар 01	Улаанбаатар хот
Хурал: 2025 оны 04-р сарын 30-ны өдрийн 13.00 цагт Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Ажилчны гудамж 51/1 тоот “Асби” ХК-ийн хурлын танхимд боллоо.		

Хурлын ирц: Хуралд нийт 59,670 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч оролцсоноос танхимд 4 хувьцаа эзэмшигч ирсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц болон хурал хүчин төгөлдөр болсон тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 сарын 20-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай 01 тоот тогтоолоор томилогдсон Тооллогын комиссын 2025 оны 04 сарын 30-ны өдрийн 01 дугаартай тогтоолыг Тооллогын комиссын дарга М.Сугармаа уншиж танилцууллаа.

Тогтоолд: “Асби” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 63,456 ширхэг хувьцаа эзэмшдэг 57 хувьцаа эзэмшигчээс 4 хувьцаа эзэмшигч ирж хуралд оролцсон нь 59,670 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 94.03% болж Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээж, хурлын дарга Д.Лхагвасүрэн үг хэлэв.

-Сайн байцгаана уу. Цаг заваа зориулан хуралдаа ирсэн та нарт баярлалаа. Ингээд хэлэлцэх асуудлуудаа хэлэлцээд шийдвэрүүдээ гаргаад явъя.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, хараат бус аудиторын дүгнэлтийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
3. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах

Хэлэлцэх асуудал 1. -Компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт болон үйл ажиллагааны тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах, эсэх

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Зөвшөөрсөн 59670 ширхэг 100%

Татгалзсан 0%

Түтгэлзсэн 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хэлэлцэх асуудал 2. - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Гишүүдийн танилцуулгыг танилцуулж хүргүүлсэн байгаа.

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүн сонгох санал хураалтын дүн:

1. Д.Лхагвасүрэн 59670 ширхэг буюу 100%-ийн санал
2. Л.Сүмбанд 59670 ширхэг буюу 100%-ийн санал

3. Ч.Дашцэрэн 59670 ширхэг буюу 100%-ийн санал
4. С.Буман-Эрдэнэ 59670 ширхэг буюу 100%-ийн санал
5. Б.Доржсүрэн 59670 ширхэг буюу 100%-ийн санал
6. С.Бат-Эрдэнэ 59670 ширхэг буюу 100%-ийн санал

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгох санал хураалтын дүн:

1. Э.Буянтогтох 59670 ширхэг буюу 100%-ийн санал
2. Ц.Хадаа 59670 ширхэг буюу 100%-ийн санал
3. Л.Нямдаваа 59670 ширхэг буюу 100%-ийн санал тус тус 100%-ийн санал өгсөн байх тул Компанийн тухай хуулийн 77.4 дэх заалт, СЗХ-ны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д заасны дагуу шийдвэр хүчинтэй болж байна.

Хэлэлцэх асуудал 3. - Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах

Энэ жилийн ТУЗ-ын төсвийг өнгөрсөн жилийн төсөвтэй ижил байхаар 900,000 төгрөгөөр батлуулахаар оруулсан байгаа.

-Тооллогын комиссын дарга Санал хураалтын дүнг танилцуулах нь:

Зөвшөөрсөн 59670 ширхэг 100%

Татгалзсан 0%

Түтгэлзсэн 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн Хурлын тогтоол баталж, Хурлын дарга Д.Лхагвасүрэн дээрх дүгнэлтийг үндэслэн хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар ХЭХ-ын тогтоол тус бүрийг уншиж танилцуулан батлав.

Цаашид компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх тал дээр дорвитой арга хэмжээ авахыг гүйцэтгэх захиралд үүрэг болгов.

Ийнхүү энэ удаагийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдэв.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Д.Лхагвас
А.Намуунтуул
М.Сугармаа

Д.ЛХАГВАСҮРЭН
А.НАМУУНТУУЛ
М.СУГАРМАА